


БАТЛАВ:

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА  Х. БАТТУЛГА

ӨВӨР ЭРЭЭН, ЗАЯАТ, УРТ, БЭРХ БАГУУДЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ
ЖИЖИГ ГОЛУУДЫН ГАРМАНД КОЛЬЦОО ТАВЬЖ ЗАСВАРЛАХ

АЖЛЫН ДААЛГАВАР

Баян-Уул сум

Зураг төсөв зохиох үндэслэл	<ul style="list-style-type: none">-Автозамын тухай хууль-Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр-Дорнод аймгийн 2016-2025 оны хэтийн зорилт-Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр-Баян-Уул сумыг 2021-2024 онд хөгжүүлэх мөрийн хөтөлбөр-Баян-Уул сумын Өвөр эрэн багийн Үйсэн гол, Урт багийн Хөсөө гол, Заяат багийн Хужиртааны гол, Бэрх багийн Бэрхийн голууд сүүлийн жилүүдэд хур бороо элбэгтэй, шавар ус ихтэй болж иргэд зорчиход хүндрэлтэй болсон. Ийм учраас иргэдийн ая тухтай, аваар осолгүй зорчих нөхцөлийг хангаж 2024 онд сумын Орон Нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгө 45.0 сая төгрөгийн санхүүжилтээр эдгээр жижиг голуудад кольцоо тавьж засварлах шаардлагтай болсон..
Барилга байгууламжийн байршил, чиглэл	Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрээн, Заяат, Урт Бэрх багийн нутагыг дамжин өнгөрч Улз голд цутгадаг жижиг голуудын гарам, замыг, голын урсацыг нь хаахгүйгээр кольцоо тавьж сайжруулан засварлах
Захиалагч байгууллага	Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар
Хөрөнгийн эх үүсвэр	Сумын ОНХСангийн хөрөнгө оруулалт
Ажлын зураг төсөв боловсруулахад ашиглах материал	Монгол улсын хуулиуд: <ul style="list-style-type: none">- Автозамын тухай хууль-Байгаль орчныг хамгаалах тухай хууль-Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль-Баян-Уул сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Норм нормативууд: <ul style="list-style-type: none">-Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт-Зам засвар, арчилгааны зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм
Зориулалт, хүчин чадал:	Тухайн багуудийн иргэд малчдын амьжиргаа, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ая тухтай зорчиход маш их дэмжлэг болохуйц голуудын гарам, зам учраас засаж сэргээх нэн шаардлагтай
Технологийн шийдэл:	Тухайн жижиг голуудын гарам, замыг Автозамын

	тухай хууль, засварын төсөл боловсруулах норм дүрэм, сүүлийн үеийн хүчин чадал сайтай / ковш, гридер, эксковотар/ зэрэг техникийг ашиглан сэргээн засварлаж тохижуулах
Зураг төслийн бүрэлдэхүүн:	-Замын өнөөгийн иж бүрэн зураг -Ажлын зураг, ажлын даалгаварын төсөв 2 хувийн хамт захиалагчид, үндсэн хувийг архивт хүлээлгэн өгнө.
Архитектор төлөвлөлтөд тавигдах шаардлага:	Замын бүтэц: - Тус багуудын жижиг голууд нь Улз голд цутгаж шороон замаар холбогддог, голуудын өргөн нь зарим газраа 2-4 метр өргөнтэй хур бороо ихтэй жил эргээ хальж үерэлдэг, зарим газраа эрэг дагуу зам нь усанд идэгдэж техник явахад хүндрэлтэй болсон, өвлийн цагт цас орж халтиргаа гулгаа ихтэй мөс нь цөмрөх аюултай болсон. -Замыг засаж сэргээхэд хүчин чадал сайтай техник ковш, гридер, хүнд даацын ачааны машин зэрэг техникүүд зайлшгүй шаардлагтай. - Эдгээр голуудад замын гарман дээр нь 2-с доошгүй 1000 мм баггүй амтай кольцоо зэрэгцүүлж байрлуулах. - Багийн нутаг дэвсгэрт байрлах хуучин зам засаварын карьераас нь хайрга чулуутай шороо татаж замын дагууд нь асгаж, хоёр талын эрэгнээс кольцоо дээгүүр зузаан хучиж буулган тэгшлэж нягтруулах. - Кольцоо тавьсан зарим хэсгийг нь өргөсгөж 2 техник зөрж өнгөрөх боломжтой болгож засах. - Голуудын гарам дээр тавьсан кольцооноос гадагш хоёр талруу эвдэрсэн замыг нь шороо асгаж далан татаж өндөрлөх - Эдгээр 4 голуудын гарамыг ижил төстэй, шардлагтай бол өргөн газар нь кольцоо нэмж зэрэгцүүлж байрлуулах. Голуудын орж гарч байгаа гармын дагуу замуудыг шавар усанд идэгдэхгүйгээр өндөрлөж засах.
Зургийн үе шат, хугацаа	-Бодит байдлын талаарх судалгааг хийх -Захиалагч талын хүсэлтийн дагуу эх загвар зураг гаргах, ажлын зураг төсвийг боловсруулах -Зураг төсөл 1 үе шаттай -Хугацаа: Гэрээнд заагдсан хоног хугацаа
Зураг төслийн байгууллага	Зам засварын бүтцийн зураг төсөл зохиох эрх бүхий мэргэжлийн байгууллага байна.
Галын аюулгүй байдлын нөхцөл	Галын аюулгүй байдлыг баримтлаж ажиллах, норм дүрэм, стандартын дагуу зураг төсвийг боловсруулах
Байгаль орчны үнэлгээ, нөхцөл	БНБД 81-95-12 төсөв зохиох дүрмийн дагуу
Онцгой нөхцөл	-Зам засварын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн

<p>/Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд, трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи гэх мэт/</p>	<p>хувьд үр ашигтай орчин үеийн хүчин чадал сайтай техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх -Замын зураг төсөв боловсруулах явцад ашиглагч, захиалагч байгууллагатай зөвшилцөх -Замыг засах явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ой модыг хамгаалах.</p>
--	--

Боловсруулсан:

Засаг даргын орлогч

 С.Цэрэнбадрал

Газрын даамал

 Л.Отгон-Иш